



World Vision
Дэлхийн Зөн Монгол

ДЗОУБ-ДУНДГОВЬ ОНХХ- ӨӨС ХУЛД СУМЫН ЕБС-Д ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2018-05-18

1. ДЗОУБ, “Монгол өрх” хүрээлэн хамтран зохион байгуулсан “Хариуцлагатай хамтарсан баг” сургалтанд хамрагдсаны дагуу сумын 7 өрхийг сонгон **“Миний гэр бүлийн баяр хөөр”** сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.



2. ДЗОУБ-аас зохион байгуулсан “Гэрээр айлчлагч” сургалтанд хамрагдаж сургагч 5 багш 10 өрх сонгон, ажлын төлөвлөгөө боловсруулан сургалтыг зохион байгуулсан.



3. Сумын нийгмийн халамжийн ажилтан А. Нямцэрэнгийн зохион байгуулсан “Зорилтот бүлэг”-ийн сургалтанд хамрагдаж буй өрхүүдэд ДЗОУБ-ын зохицуулагч Ө. Өлзиймаатай хамтран “Гэрээр айлчлагч”-ын ажил байдлын талаар мэдээлэл өгч, сургалт зохион байгуулав.



4.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр “Өртөөчилсөн аялал”-ыг ДЗОУБ-ын дэмжлэгтэйгээр Сумын нийгмийн бодлогын ажилтан, Гэрээр айлчлагчид, эцэг эхийн төлөөлөл, сурагчдын оролцоотойгоор зохион байгууллаа.



5. ДЗОУБ-ын байгууллагын зохион байгуулсан “Гэрээр айлчлагч” сургалтанд шинэчилсэн бүрэлдэхүүнээр сургалтанд хамрагдсны дагуу сумын 7 өрх сонгон, өрхүүддээ сургалт зохион байгуулан гэрээр нь айлчлан, сургуулийн сурагчдад зориулан тусгайлан сургалт явууллаа.



6. ДЗОУБ-ын хөрөнгө оруулалтаар дотуур байрны багш, НТБ-ын арга зүйч нар хамтран “Тогтвортой хөгжил”-ийн талаар дотуур байрын сурагчдад сургалт зохион байгуулав.



7. “Өнөөдрийн оролцоо-маргаашийн боломж” спортын өдөрлөгт Дэлгэрхангай суманд амжилттай оролцов.



8. Математикийн кабинетэд 1 сая төгрөгөөр ханын үзүүлэнгийн тохижилт хийгдэв.



9. Ариун цэврийн байгууламж- 90 сая төгрөг сургууль, дотуур байрны нэгдсэн халаалт – 29 сая төгрөгөөр хийгдэв.



10. Хүүхдийн чуулганыг сүүлийн 10 гаруй жил хамтран зохион байгуулж нийт 580 гаруй хүүхэд оролцож сум орон сургууль өөрт болон найз нартаа тус дэм болох шийдвэр гаргасан байна. Нийт өртөг 5000000 сая гаруй болсон байна.



11.ДЗОУБ. Дундговь ОНХХ газартай хамтарч Аймагт анхлан “Аавуудын чуулган”-ыг 2008-2014 онуудад зохион байгуулсан үүний үр дүнд аавууд маань гэр бүл, үр хүүхдийнхээ хүмүүжил боловсролд ихээхэн анхаарал халамж тавьдаг болсон. Нийт 7удаа болж 350 гаруй аав оролцож нийт төсөв 5.7 сая төгрөг



12. 2012-2017 оны хооронд сумын хүүхдийн төлөө зөвлөл,Хамтарсан багтай Дундговь ОНХХ –ын Хүүхэд хөгжлийн ажилтан Ө.Өлзиймаа хамтарч ажиллаж бид хүүхдийн төлөө олон сайхан зүйл хамтдаа бүтээлээ.



- Засаг даргаар ахлуулсан сумын Хамтарсан баг нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж энэ оны 4 сарын байдлаар ээлжит хурал 3 удаа ээлжит бус хурал 1 удаа хийж суман дахь хүүхэд хамгааллын бодлого шийдвэрийг хэрэгжүүлж байна. Оны эхээр “Хүүхэд хамгаалал төлөвшил хүмүүжил” “хүүхдийн эрүүл мэнд” “Хүүхдийн авьяасыг хөгжүүлэх” “Хүүхдийн оролцоог хангаж хамгаалах бодлого” гэсэн 6 бүлэг 21 заалт бүхий төлөвлөгөөг олон талын оролцоотой боловсруулан ажиллаж байна.

13. Мөн Хүүхдийн асран хамгаалагч нарт олон төрлийн сургалтыг ДЗОУБ-тай хамтарч зохион байгуулсан байна. тухайн сургалт жилд 2-5 удаа зохион байгуулсан гэж үзвэл нийт 30 Гаруй удаа явуулж давхардсан тоогоор 1600 гаруй эцэг эхэд оюуны хөрөнгө оруулалт хийсэн байна.



14. 2013-14 оны хичээлийн жилд Англи хэлний кабениит байгуулах төслийн 3.6 сая төгрөгны өртгөөр байгуулж хүүхэд багшийн хөгжилд бодит хувь нэмэр оруулав .



15. Ширээний теннис хөгжүүлэхэд Зширхэг буудагч машин теннисны бандан 3 хосыг олгож сургууль маань аймгийн баруун бүсийн теннисны тэмцээнийг амжилттай зохион байгуулж сурагчид хөгжиж байна.



16. Хүүхэд хөгжлийн өрөөг 5.4 сая төгрөгөөр байгуулж хүүхдүүд хөгжих СОУЗ үйл ажиллагаа явуулах орчин бүрдсэн мөн аймагт анхлан бага ангийн багш Б.Эрдэнэчимэг цахим сургалтын орчин бүрдүүлэхэд 3.8 сая төгрөгөөр дэмжиж хүүхэд хөгжих суралцах орчин бүрдэв.



17. Сурагчдыг үндэсний өв соёлоос суралцуулах бахархал бий болгох үүднээс үндэсний хөгжмийн төслийг 5.6 сая төгрөгөөр нийлүүлж одоогоор үе үеийн үндэсний хөгжмийн хамтлаг 3, морин хуурч хүүхэд 80 гаруй төрөөд байна.



18. Хүүхдийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад бидний хамтын ажиллагаа болсон нэгэн жишээ Зөнгийн одод урлагийн бага наадмыг жил бүр зохион байгуулж ирлээ.



19.Хүнд нөхцөлд байгаа хүүхэд бүрт бидний анхаарал дэмжлэг хамгаас чухал



- Зорилтод бүлгийн 22 өрхийг хүнс хөтөлбөрт хамруулж уг хөтөлбөрт 55 хүүхэд сар бүр 6500 төгрөгний хүнс авдаг. Хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаа сувилгаа шаардлагатай 12 хүүхдийг эцэг эхийн халамжинд байлган амьжиргааг дэмжих тэтгэлэг болгон тус бүр 126500 төгрөг олгож байна.
- Дэмжлэг шаардлагатай сумын 14 өрхөд төсөвт болон ААН,ТББ, ард иргэд ахуйн дэмжлэг үзүүлж байна. Хичээлийн хэрэглэл, хувцас , хоол хүнс , ахуйн хэрэглэл , мөнгөн хуримтлал.Сургуулийн захиргаа энэ хичээлийн жилд 7 хүүхдэд 120 гаруй мянган төгрөгний дэмжлэг үзүүлэв.

20.2012-14 онуудад сурагчдын дунд дугуйлан хичээллүүлэх орчин бүрдүүлснээр 200 гаруй цагийн дугуйланд 460 гаруй хүүхэд хамрагдаж аймаг, сумын хэмжээнд олон амжилтыг бид хамтдаа бүтээлээ.



21.2014 онд шатрын клуб байгуулан 16 шатар иж бүрэн үзүүлэн нийлүүлж оюуны спортыг дэмжив. Үүний үр дүнд аймаг бүсийн аварга 7 төрөн гарсан шатраар хичээллэх хүүхдийн тоо олширсон



22. Хулд сумын ЕБС-ийн “НОМЫН САН” төслийн хүрээнд 2 сая гаруй төгрөгний төсөл хэрэгжүүлсэн.

